



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/26/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024 оны 02 дугаар сар 20</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК Захирал Г.Саранчимэг Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com Аудитор:: О.Мандах Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



「БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХДИЙН
ТЭМҮЖИН ТЕАТРЫН ДАРГА
Ж.БАТБОЛД ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/44
танай _____-ны № _____-т

「**Өөрчлөлтгүй дүгнэлт**」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71702 хөтөлбөрийн 2 арга хэмжээний зардалд төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 25,677.2 мянга, улсын төсвөөс 824,561.1 мянга, орон нутгийн төсвөөс 118,182.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 749,343.0 мянган төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант оны эцэст 93,863.5 мянган төгрөг байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар улирлын үр дүнгийн урамшууллыг сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд олгосон алдаа

5020181

зөрчил гарсан боловч илэрсэн зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг алдааны түвшнээс бага байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай тайлагнасныг 92 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including 'АУДИТОР' (Auditor) and 'Төрийн аудитын байгууллага' (State Audit Agency). The signature is written in a cursive style.

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	121,118,405.54	208,410,997.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,667,288.54	93,863,530.68
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,667,288.54	93,863,530.68
31210	Төгрөг	16,667,288.54	93,863,530.68
31211	Төрийн сангийн харилцах	16,667,288.54	93,863,530.68
33	АВЛАГА	427,133.00	3,520,933.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	427,133.00	3,520,933.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,023,984.00	111,026,534.00
35100	Түүхий эд материал	6,099,190.00	6,099,190.00
35110	Тусгай зориулалттай материал	6,099,190.00	6,099,190.00
35400	Хангамжийн материал	97,924,794.00	104,927,344.00
35410	Бичиг хэргийн материал	92,100.00	92,100.00
35420	Аж ахуйн материал	5,103,100.00	4,541,100.00
35450	Барилгын засварын материал	240,000.00	240,000.00
35470	Бусад хангамжийн материал	92,489,594.00	100,054,144.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	75,534,694.16	160,995,193.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	75,534,694.16	160,995,193.94
39200	Биет хөрөнгө	59,298,594.16	138,059,093.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,791,666.00	18,375,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,263,888.64	-1,531,250.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	136,515,451.00	169,160,451.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99,084,070.51	-116,116,143.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,539,396.00	156,029,396.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-106,096,959.69	-89,596,959.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,474,500.00	2,474,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,682,500.00	-1,840,900.00
39217	Ном	1,105,000.00	1,105,000.00
39300	Биет бус хөрөнгө	16,236,100.00	22,936,100.00
39301	Программ хангамж	2,050,000.00	2,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-575,000.00	-875,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,761,100.00	21,761,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	196,653,099.70	369,406,191.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	196,653,099.70	369,406,191.62
51	Засгийн газрын хувь оролцоо	196,653,099.70	369,406,191.62
51100	Засгийн газрын оруулсан капитал	137,949,437.69	137,949,437.69

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	137,949,437.69	137,949,437.69
51200	Хуримтлагдсан үр дүн	35,602,301.01	208,355,392.93
51210	Өмнөх үеийн үр дүн	-166,370,470.82	35,602,301.01
51220	Тайлант үеийн үр дүн	201,972,771.83	172,753,091.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,101,361.00	23,101,361.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	196,653,099.70	369,406,191.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	670,672,235.84	1,010,136,548.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	157,812,135.84	93,694,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	157,812,135.84	93,694,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,639,500.00	28,279,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,639,500.00	21,769,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	6,510,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	64,424,751.84	65,415,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	87,747,884.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,860,100.00	916,441,748.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	412,425,500.00	798,259,448.14
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	412,425,500.00	798,259,448.14
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,160,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,160,000.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,274,600.00	118,182,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,274,600.00	118,182,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	468,699,464.01	837,383,456.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,699,464.01	837,383,456.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,023,112.01	677,571,777.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,380,908.00	384,810,004.00
210101	Үндсэн цалин	281,380,908.00	284,107,368.00
210102	Нэмэгдэл	0	59,479,930.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	17,127,085.00
210104	Урамшуулал	0	24,095,621.00

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,764,318.33	47,167,368.00
210201	Тэтгэврийн даатгал	34,764,318.33	32,708,853.00
210202	Тэтгэмжийн даатгал	0	3,848,093.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	3,078,481.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0	684,720.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0	6,847,221.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,848,248.00	101,656,002.38
210301	Гэрэл, цахилгаан	2,178,198.00	2,869,358.58
210302	Түлш, халаалт	74,304,446.00	90,469,211.80
210303	Цэвэр, бохир ус	8,365,604.00	8,317,432.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,902,400.00	38,492,000.00
210401	Бичиг хэрэг	1,689,200.00	2,106,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,618,000.00	7,575,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	439,000.00	471,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956,200.00	1,468,300.00
210408	Бараа материал акталсны зардал	0	26,270,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,850,000.00	15,331,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	1,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,050,000.00	0
210604	Урсгал засвар	3,800,000.00	14,331,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,160,000.00	6,313,000.00
210702	Дотоод албан томилолт	426,000.00	6,313,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,734,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,446,700.00	30,409,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,446,700.00	30,229,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,670,537.68	53,392,853.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,671,580.00	32,331,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,998,957.68	21,061,653.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,676,352.00	159,811,678.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,268,000.00	153,697,534.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	107,215,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	45,713,934.00

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,408,352.00	1,626,297.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,408,352.00	1,626,297.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	4,487,846.96
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0	4,487,846.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	201,972,771.83	172,753,091.92
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	201,972,771.83	172,753,091.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	518,499,600.00	944,721,548.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,639,500.00	28,279,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,639,500.00	28,279,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,639,500.00	28,279,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,639,500.00	21,769,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	6,510,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,860,100.00	916,441,748.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	412,425,500.00	798,259,448.14
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	412,425,500.00	798,259,448.14
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,160,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,160,000.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,274,600.00	118,182,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,274,600.00	118,182,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	470,723,411.46	821,930,306.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,723,411.46	821,930,306.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467,047,059.46	666,606,474.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,918,784.00	387,903,804.00
210101	Үндсэн цалин	244,521,145.00	287,201,168.00

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	23,515,262.00	59,479,930.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	17,127,085.00
210104	Урамшуулал	10,577,577.00	24,095,621.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,304,800.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,973,247.46	47,167,368.00
210201	Тэтгэврийн даатгал	25,579,100.00	32,708,853.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,494,903.00	3,848,093.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,745,129.29	3,078,481.00
210204	Ажилгүйдлийн даатгал	241,469.17	684,720.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,912,646.00	6,847,221.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,848,248.00	101,656,002.38
210301	Гэрэл, цахилгаан	2,178,198.00	2,869,358.58
210302	Түлш, халаалт	74,304,446.00	90,469,211.80
210303	Цэвэр, бохир ус	8,365,604.00	8,317,432.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,902,400.00	12,221,600.00
210401	Бичиг хэрэг	1,546,300.00	2,063,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,618,000.00	7,618,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	481,900.00	471,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956,200.00	1,468,300.00
2105	Нормативт зардал	450,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,300,000.00	16,090,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	1,190,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	0
210604	Урсгал засвар	3,800,000.00	14,900,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	6,313,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	6,313,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,805,800.00	47,242,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,805,800.00	47,062,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,848,580.00	48,012,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,848,580.00	48,012,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,676,352.00	155,323,831.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,268,000.00	153,697,534.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	107,215,600.00

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	45,713,934.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,408,352.00	1,626,297.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,408,352.00	1,626,297.62
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	47,776,188.54	122,791,242.14
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	31,108,900.00	45,595,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,108,900.00	45,595,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,108,900.00	45,595,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,108,900.00	45,595,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-31,108,900.00	-45,595,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	16,667,288.54	77,196,242.14
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	16,667,288.54
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,667,288.54	93,863,530.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	137,949,437.69	23,101,361.00	-166,370,470.82	-5,319,672.13
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-166,370,470.82	-5,319,672.13
4	Тайлант үеийн үр дүн	0	0	201,972,771.83	201,972,771.83
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	35,602,301.01	196,653,099.70
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	35,602,301.01	196,653,099.70
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	35,602,301.01	196,653,099.70
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	208,355,392.93	369,406,191.62

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,667,288.54	-16,667,288.54	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	958,786,334.00	865,899,008.38	-92,887,325.62	90.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	958,786,334.00	865,899,008.38	-92,887,325.62	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,242,300.00	712,201,474.38	-74,040,825.62	90.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,094,500.00	387,903,804.00	-63,190,696.00	86.0
210101	Үндсэн цалин	299,786,600.00	287,201,168.00	-12,585,432.00	95.8
210102	Нэмэгдэл	87,394,200.00	59,479,930.00	-27,914,270.00	68.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,296,000.00	17,127,085.00	-4,168,915.00	80.4
210104	Урамшуулал	42,617,700.00	24,095,621.00	-18,522,079.00	56.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,387,100.00	47,167,368.00	-9,219,732.00	83.6
210201	Тэтгэврийн даатгал	38,343,000.00	32,708,853.00	-5,634,147.00	85.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,510,900.00	3,848,093.00	-662,807.00	85.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,608,800.00	3,078,481.00	-530,319.00	85.3
210204	Ажилгүйдлийн даатгал	902,200.00	684,720.00	-217,480.00	75.9
210205	Эрүүл мэндийн даатгал	9,022,200.00	6,847,221.00	-2,174,979.00	75.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,282,300.00	101,656,002.38	-1,626,297.62	98.4
210301	Гэрэл, цахилгаан	3,460,000.00	2,869,358.58	-590,641.42	82.9
210302	Түлш, халаалт	91,430,300.00	90,469,211.80	-961,088.20	98.9
210303	Цэвэр, бохир ус	8,392,000.00	8,317,432.00	-74,568.00	99.1
210304	Байрны түрээс	00.00	00.00	0.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,221,600.00	12,221,600.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,063,400.00	2,063,400.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,618,000.00	7,618,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	484,000.00	471,900.00	-12,100.00	97.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,456,200.00	1,468,300.00	12,100.00	100.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,208,100.00	26,205,000.00	-3,100.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,308,100.00	11,305,000.00	-3,100.00	100.0
210604	Урсгал засвар	14,900,000.00	14,900,000.00	00.00	0.0
2107	Томилолт, зочны зардал	6,314,000.00	6,313,000.00	-1,000.00	100.0
210702	Дотоод албан томилолт	6,314,000.00	6,313,000.00	-1,000.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,984,200.00	60,984,200.00	0.00	100.0

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,804,200.00	60,804,200.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	180,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,750,500.00	69,750,500.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,750,500.00	69,750,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	172,544,034.00	153,697,534.00	(18,846,500.00)	89.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	172,544,034.00	153,697,534.00	-18,846,500.00	89.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,062,100.00	107,215,600.00	-18,846,500.00	85.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,713,934.00	45,713,934.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	850,238,300.00	826,539,248.14	-23,699,051.86	97.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	824,561,100.00	798,259,448.14	-26,301,651.86	96.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	824,561,100.00	798,259,448.14	-26,301,651.86	96.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,677,200.00	28,279,800.00	2,602,600.00	110.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,167,200.00	21,769,800.00	2,602,600.00	113.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,510,000.00	6,510,000.00	0.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	16,667,288.54	16,667,288.54	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	93,863,530.68	93,863,530.68	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00	0.00	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	18.00	18.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00	0.00	100.0

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театр нь “Сургалт, уран бүтээлийн үйл ажиллагаа явуулах. Байгууллагын зорилт: Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, чанартай үйлчилгээ таатай орчин, технологийн шинэчлэлтэд тулгуурлаж үзэгчид, суралцагч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх мэргэжлийн чиг баримжаа олгож тэдэнд урлагийн боловсролоор дамжуулан хүүхдийн бахархалт бүтээлийг бий болгох, орчин үеийн болон сонгодог ардын өв соёл биет болон биет бус өвийг сэргээн өвлүүлэх уран бүтээлийг нийтэд түгээх дэлгэрүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Хүүхдийн Тэмүжин театр нь уран сайхны зөвлөл, уран бүтээл сургалт, үйлдвэр техник, үзвэр үйлчилгээ маркетинг гэсэн 4 албатайгаар нийт 26 албан хаагчтай үйл ажиллагааг явуулахаар даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дугаар тушаалаар баталсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг байгууллагын дарга Ж.Батболд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч М.Мөнхбат нар зурж, нярваар Б.Наранцацрал нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Соёлын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд тус бичиг баримт нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,972.0 мянган төгрөгөөр бууу 6.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,667.20	93,863.50	77,196.30
Авлага	427.1	3520.9	3,093.80
Бараа материал	104,023.90	111,026.50	7,002.60
Үндсэн хөрөнгө	286,237.10	370,955.40	84,718.30
Хуримтлагдсан элэгдэл	-210,702.40	-209,960.20	742.20
Нийт хөрөнгө	196,653.00	369,406.10	172,753.10
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	196,653.00	369,406.10	172,753.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	196,653.00	369,406.10	172,753.10

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баацагаан сумын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 77,196.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант батлагдсан орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой хэмнэгдсэн цалингийн зардал байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 3,093.8 мянган төгрөгөөр өссөн нь холбоотой авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл нь өмнөх оноос 111,026.5 мянган төгрөг болж 7,002.6 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал дансны үлдэгдэл өмнөх оноос 7,564.5 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 370,955.4 мянган төгрөг болж 84,718.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 32,645.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,950.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 2000.0 мянган төгрөгийн дууны фонограмм, 5000.0 мянган төгрөгийн Хөвчийн борхон бамбуй жүжгийн зохиол худалдан авсан, аймгийн ИТХ-ын даргын 2023.07.28-ны өдрийн 67 дугаар захирамжаар Заг сумын соёлын төвөөс шилжүүлэн 18,375.0 мянган төгрөгийн Alphard

маркийн 32-14 БНА улсын дугаартай тээврийн хэрэгсэл, 47,040.0 мянган төгрөгийн Үзэгчийн сандлыг аймгийн аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар шилжүүлэн авч данс бүртгэлд бүрэн тусгасан байна. Харин аймгийн ИТХ-ын 2023.11.13-ны өдрийн 108 дугаар захирамжаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 4,487.8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй HYUNDAI STAREX маркийн 98-02БНА улсын дугаартай тээврийн хэрэгслийг Баянхонгор сумын ЗДТГ-т шилжүүлэн өгсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 884,519.9 мянга, орон нутгийн төсвөөс 124,182.3 мянган төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 233,651.7 мянган төгрөгөөр бууруулж 656,868.2 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор мянган төгрөг болгож 118,182.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь цалин, хөлс нэмэгдсэн мөн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байгаатай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71702 хөтөлбөрийн 80101, 80214, 80802, 81855, 83603, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 775,050.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 656,868.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 118,182.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 751,884.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 118,182.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 743,343.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 116,556.0 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 1,626.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант оны эцэст 93,863.5 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 93,863.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Код	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Хувь
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	594,112.60	521,703.57	(72,409.03)	87.8
2	80214	Уран бүтээл хийлгэх	20,000.00	20,000.00	-	100.0
3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	182,178.30	153,697.53	(28,480.77)	84.4
4	81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	28,270.20	28,264.70	(5.50)	100.0
5	83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	25,677.20	25,677.20	-	100.0
6	80112	Нийтлэг үйлчилгээ	118,182.30	118,182.30	-	100.0
		Нийт	968,420.60	867,525.31	(100,895.29)	89.6

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 837,383.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,373.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 6,280.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 932,586.0 мянган төгрөгийн 26 гүйлгээ, зарлагын 236,267.4 мянган төгрөгийн 26 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 12 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

	Мэдээлэл байршуулах хугацаа	Мэдээллийн		Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Мэдээлээгүй	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Зөрүү
		төрөл	тоо						
1	Сар бүр байршуулах	4	48	48	48	-	-	-	-
2	Хагас жилээр байршуулах	4	4	4	4	-	-	-	-
3	Жил бүр байршуулах	11	11	11	7	-	1	3	-
4	тухай бүр байршуулах	8	96	96	96	-	-	-	-
	Дүн	27	159	159	153	0	1		0

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж аудитаар 2,530.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2103.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 427.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,103.3	2	2,103.3	100.0
Албан шаардлага	-	-	-	-	0
Зөвлөмж	1	427.1	1	427.1	100.0
Нийт дүн	3	2,530.4	3	2,530.4	100.0

Эх сурвалж: Хүүхдийн Тэмүжин театрын 2023.06.15-ны өдрийн 36 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.06.15-ий өдөр 36 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон өөрийн орлогын дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 877.7 мянган төгрөгийн зөрчил илэрснийг орон нутгийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 2023.12.15-ны өдрийн Б/66 дугаар тушаалаар 509.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.9.Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр мэдэгдэнэ; Засгийн газрын 2019.01.09-ны өдрийн 5 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журам зөрчин зарцуулсан хөрөнгийн холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт: Байгууллагын дарга Ж.Батболд нь 2023.11.03-ны өдрийн Б/64 дугаар тушаалаар өөр дэрээ 25 хувийн үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гарган 368.5 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журам зөрчин зарцуулсан хөрөнгийн холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 2023.12.15-ны өдрийн Б/66 дугаар тушаалаар үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	509.2	1	509.2	0	0	0	0	0	0	0	0
2	Байгууллагын дарга Ж.Батболд нь 2023.11.03-ны өдрийн Б/64 дугаар тушаалаар өөр дэрээ 25 хувийн үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гарган 368.5 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.	1	368.5	1	368.5								
	Нийт дүн	2	877.7	2	877.7	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн		0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0					1	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 54/14210512/БНА/2024
/26/НА-СТА-ТЦЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхдийн Тэмүүжин театрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхдийн Тэмүүжин театрын даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/66 тушаалаар ажилтанд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад үр дүнгийн урамшуулал 509,200.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.9 Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр мэдэгдэнэ. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7 "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалт Үнэ зөв бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**



1. Шийдвэр гаргаж олгосон үр дүнгийн мөнгөн урамшуулал 509,200.00

5050105

/Таван зуун есөн мянга хоёр зуун/ төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Хүүхдийн Тэмүүжин театрын дарга Ж.Батболд, нягтлан бодогч М.Мөнхбат нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ
НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР:  О.МАНДАХ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 08/14210513/БНА/2024/26/-
- НА-СТА-ТМЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхдийн Тэмүүжин театрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхдийн Тэмүүжин театрын дарга 2023 оны 11 дүгээр сарын 03 өдрийн Б/64 тушаалаар 25 хувийн үр дүнгийн урамшуулал 368,500.00 төгрөг авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр дүнгийн урамшуулалын 368,500.00 /Гурван зуун жаран найман мянга таван зуун/ төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор

5050140

аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүүхдийн Тэмүүжин театрын дарга Ж.Батболд, нягтлан бодогч М.Мөнхбат нарт хариуцуулав¹.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН

АУДИТОР:  О.МАНДАХ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно